



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 24

Мандалговь


“Сум хөгжүүлэх сан”-гийн
төсөл сонгон шалгаруулах тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.9, 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 1.11 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.“Сум хөгжүүлэх сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг 2021 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийг дуусталх хугацаанд хүлээн авч, 2021 оны 4 дүгээр сарын 16-ны дотор сонгон шалгаруулах товыг зарласугай.

2. Товлогдсон хугацааг олон нийтийн цахим, мэдээллийн хэрэгслээр 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зарлахыг Жижиг дунд үйлдвэр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (Ш.Бямба)-д үүрэг болгосугай.

3.“Сум хөгжүүлэх сан”-аас 2021 онд олгох зээлийн төсөлд, батлагдсан тэргүүлэх чиглэлийг баримтлан ажиллахыг Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл /С.Бат-Оргил/-д үүрэг болгосугай.



Т.БАТЖАРГАЛ